


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2016 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,852.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 9,519.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 3,667.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээний 84.4 хувьтай тэнцэж байна.



Монгол Улсын 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 2.2 хувиар буурч, харин нийт зарлага 33.4 хувиар нэмэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2,510.9 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2016 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-43.9	35.1	-80.6	-2.3 дахин	115.7
Засгийн газрын бонд	681.4	2,941.7	3,332.8	113.3	-391.1
Засгийн газрын зээл	572.2	1,370.8	1,461.7	106.6	-90.9
Урьдчилгаа төлбөр	-52.9	-1.4	-46.1	32 дахин	44.6
Засгийн газрын санхүүгийн хөрөнгө оруулалт	0.0	0.0	-1,000.0	0.0	1,000.0
НИЙТ ДҮН	1,156.9	4,346.2	3,667.8	84.4	678.3

Эх сурвалж: Сангийн яам

2016 оны урьдчилсан гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 135.6 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,300.4 тэрбум, богино хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 282.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, 757.8 тэрбум төгрөгийн гадаад төслийн, 587.2 тэрбум төгрөгийн төслийн бус гадаад зээл тус тус авсан байна. Засгийн газрын 3,754.2 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 1,021.4 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад, 282.8 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод бондыг тус тус арилжаалсан байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,852.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 2.2 хувиар буюу 129.0 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч төлөвлөсөн хэмжээнээс 9.4 хувиар буюу 504.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн орлого 287.5 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 58.9 тэрбум, хүний хөгжил сангийн орлого 19.4 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 123.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс давж биелжээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад хүний хөгжил сангийн орлого 233.9 тэрбум төгрөгөөр буурч, улсын төсвийн орлого 22.3 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 126.3 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 395.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Нэгдсэн төсвийн орлогын 2016 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 2. /тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		ХХС		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,566.6	3,854.0	2,101.1	2,160.0	169.7	189.1	1,752.4	1,875.9
ТОГТВОРЖУУЛСАН САН	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	3,566.6	3,854.0	2,101.1	2,160.0	169.7	189.1	1,752.4	1,875.9
УРСГАЛ ОРЛОГО	3,566.6	3,854.0	2,101.1	2,160.0	169.7	189.1	1,752.4	1,875.9
ТАТВАРЫН ОРЛОГО	2,533.8	2,843.3	755.5	790.0	166.0	187.7	1,257.5	1,381.0
Орлогын албан татвар	433.9	510.6	518.4	510.4	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1,257.5	1,381.0
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	89.7	104.6	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,081.4	1,143.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	531.8	626.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	8.6	10.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	302.2	328.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	175.9	223.4	147.4	174.9	166.0	187.7	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,032.8	1,010.8	1,345.6	1,370.1	3.7	1.4	494.9	494.9
Нийтлэг татварын бус орлого	655.5	683.3	64.7	98.8	3.7	1.4	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.2	0.2	1.4	0.7	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	284.7	236.6	2.1	4.3	0.0	0.0	494.9	494.9
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	92.3	90.7	1,277.6	1,266.2	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам


Нэгдсэн төсвийн тэнцвэр-жүүлсэн нийт орлогын 85.0 хувь нь татварын орлогоос, 15.0 хувь нь татварын бус орлогоос бүрджээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад татварын орлого 2.4 хувиар, татварын бус орлого 0.8 хувиар тус тус буурсан байна.



Татварын орлого 4,996.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн орлого 10.8 хувиар буюу 487.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 20.4 хувийг орлогын албан татвар, 23.5 хувийг нийгмийн даатгалын орлого, 2.1 хувийг хөрөнгийн албан татвар, 22.9 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 12.5 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 6.6 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 11.7 хувийг бусад татвараас бүрдүүлж байна.




Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийгмийн даатгалын шимтгэл хураамж 11.5 хувь /121.5 тэрбум.төг/, бусад татвар 19.8 хувь /96.7 тэрбум.төг/, онцгой албан татвар 17.9 хувь /95.1 тэрбум.төг/, орлогын албан татвар 7.2 хувь /68.7 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 5.7 хувь /61.8 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 8.7 хувь /26.2 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 16.7 хувь /14.9 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлогын гүйцэтгэл 25.5 хувь /2.2 тэрбум.төг/-иар тус тус давж биелжээ.

2015 онтой харьцуулахад татварын орлого 122.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Өмнөх оноос нэгдсэн төсвийн нийгмийн даатгалын шимтгэл хураамж 15.5 хувь /157.8 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 8.9 хувь /93.5 тэрбум.төг/, онцгой албан татвар 5.8 хувь /34.6 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 20.8 хувь /18.0 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны орлого 2.5 хувь /7.9 тэрбум.төг/-иар өссөн, харин орлогын албан татвар 12.8 хувь /149.8 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 8.7 хувь /1.0 тэрбум.төг/, бусад татвар 32.6 хувь /283.1 тэрбум.төг/-иар тус тус буурчээ.

Татварын бус орлого 855.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 2.1 хувиар буюу 17.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн хэдий ч өнгөрсөн оноос 6.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Татварын бус орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд навигацийн орлого 12.8 тэрбум, хүүгийн орлого 12.5 тэрбум, газрын тосны орлого 10.8 тэрбум, торгуулийн орлого 4.3 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 1.5 тэрбум, бусад орлого 24.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин тусламжийн орлого 41.3 тэрбум, хувьцааны ногдол ашиг 8.1 тэрбум, хөрөнгийн орлого 0.7 тэрбум төгрөгөөр тасарчээ.



Татварын бус орлогын 91.6 хувийг нийтлэг татварын бус орлого, 8.4 хувийг тусламжийн орлого, хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогын 33.0 хувь нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 17.1 хувь нь газрын тосны орлого, 14.8 хувь нь навигацийн орлого, 18.7 хувь нь хүүгийн орлого, 4.1 хувь нь торгуулийн орлого, 11.5 хувь нь бусад орлого эзэлж байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн дагуу 21 төсвийн ерөнхийлөн захирагч, улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 10 нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, 11 нь 2-81 хувиар тасалдуулжээ.

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч,
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3

/сая төгрөгөөр/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2015 оны гүйцэтгэл	Монгол улсын 2016 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн сайд	3,294,071	2,850,048	3,002,982	152,935	105
Гааль, татварын ерөнхий газар		1,566,781	-		
Татварын ерөнхий газар	1,568,928	443,115	1,374,712	931,597	310
Гаалийн ерөнхий газар	1,447,787	598,809	1,521,155	922,346	254
Сангийн яам	254,989	148,789	50,347	(98,442)	34
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	15,035	27,912	23,234	(4,678)	83
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,900	61,293	25,706	(35,587)	42
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	4,433	3,349	7,829	4,480	234
Монгол Улсын Ерөнхий сайд	30,249	15,389	9,676	(5,713)	63
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	2,270	3,100	2,059	(1,041)	66
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	25,408	8,285	4,068	(4,217)	49
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2,571	4,004	3,549	(454)	89
Монгол Улсын Шадар сайд	9,065	9,072	15,903	6,831	175
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	714	2,190	2,868	677	131
Стандартчилал, хэмжил зүйн газар	1,723	1,500	3,454	1,954	230
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	61	-	-	-	-
Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	1,817			-	-
Хилийн мэргэжлийн хяналтын алба	-			-	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	983	631	4,676	4,044	741
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,768	4,751	4,906	156	103
Гадаад харилцааны сайд	10,747	7,371	15,372	8,002	209
Дипломат төлөөлөгчийн газрууд	6,128	5,000	14,694	9,694	294
“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” улсын төсөвт үйлдвэрийн газар УТҮГ	4,085	-	-	-	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	13	11	16	5	150
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	521	2,360	662	(1,698)	28
Хууль зүй, дотоод хэргийн сайд	30,767	63,555	47,979	(15,575)	75
Бүртгэл, статистикийн ерөнхий газар		9,129	-	(9,129)	-
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	14,649	9,749	22,701		
Цагдаагийн ерөнхий газар	1,708	3,600	2,517	(1,083)	70
Архивын ерөнхий газар	50	-	-	-	-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	-	1,231	7,859	6,628	638
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн					-

төлөлт	-	22,177	-	(22,177)	
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	962	963	-	(963)	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	13,398	16,706	14,902	(1,804)	89
Барилга, хот байгуулалтын сайд	9,147	4,606	2,421	(2,185)	53
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1,604	1,855	1,684	(171)	91
Барилга, хот байгуулалтын яам	771	1,000	350	(650)	35
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,772	1,751	387	(1,364)	22
Зам, тээврийн хөгжлийн сайд	105,603	106,194	122,915	16,721	116
Иргэний нисэхийн ерөнхий газар	95,626	103,088	115,844	12,757	112
Зам, тээврийн хөгжлийн яам	100	150	150		
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,814	1,036	1,935	899	187
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,063	1,920	4,985	3,065	260
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	215,595	167,545	183,273	15,729	109
Ашигт малтмалын газар	49,449	20,688	-		
Газрын тосны газар	164,610	69,222	-		
Ашигт малтмал, газрын тосны газар		70,343	176,356	106,013	251
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1,535	7,291	6,917	(374)	95
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	69,728	56,756	45,694	(11,062)	81
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	420	420	420		
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого		368.00	-		
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		5,159	-		
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа, мэдээллийн үндэсний төв		-	-	-	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	69,308	50,809	45,274	(5,535)	89
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	12,427	161,999	129,169	(32,831)	80
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	1,274	76,000	51,870	(24,130)	68
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	6,639	13,892	19,473	5,581	140
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	4,513	72,107	57,826	(14,281)	80
Аж үйлдвэрийн сайд	74,621	-	-	-	-
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	39,978	-	-	-	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	34,643	-	-	-	-
Батлан хамгаалахын сайд	43,376	48,679	49,764	1,085	102
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	4,960	5,085.77	-	(5,086)	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	38,416	43,593	49,764	6,171	114
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	4,013	-	-	-	-

Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	577	-	-	-	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,436	-	-	-	-
Эрүүл мэндийн сайд	153,384	193,162	21,136	(172,026)	11
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	135,136	168,322.01	-	(168,322)	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,628	1,014	1,217	202	120
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	16,620	23,826	19,919	(3,907)	84
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1,504	8,477	6,822	(1,655)	80
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,020	8,196	6,370	(1,827)	78
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	485	281	452	172	161
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	3,722	12,672	6,939	(5,733)	55
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		7,923	2,792		
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	3,722	4,750	4,147	(603)	87
Эрчим хүчний сайд	4,528	5,299	785	(4,514)	15
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,528	5,299	785	(4,514)	15
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		-	-	-	
Монгол Улсын Их Хурлын дарга	2,357	2,073	2,249	176	108
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		-	21	21	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,357	2,073	2,227	155	107
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	36	10	33	23	329
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	36	10	33	23	329
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	2,557	1,035	1,382	347	134
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,428	212	173	(40)	81
Санхүүгийн зохицуулах хороо	110	-	-	-	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	1,020	822	1,209	387	147
Авлигатай тэмцэх газар	-	97	159	63	165
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		97	159	63	165
Монгол улсын Ерөнхий Аудитор	4,965	-	625	625	-
Аудитын шалгалтын орлого	4,946	-	194	194	-
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	19	-	431	431	-
Үндэсний статистикийн хорооны дарга	12	394	6	(388)	2
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		388	-		
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	12	6	6	0	101
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	459	1,178	709	(470)	60
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого		143	113	(30)	79
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	459	1,036	596	(440)	58

Эх сурвалж: Сангийн яам

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 9,519.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 98.2 хувийг ашиглаж, 173.5 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2016 оны урьдчилсан гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 4. /тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		ХХС		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,749.7	7,367.3	2,137.7	2,314.9	283.9	278.5	1,764.8	1,786.2
УРСГАЛ ЗАРЛАГА	5,212.5	5,031.2	1,699.6	1,850.1	283.9	278.5	1,761.8	1,780.9
Бараа, үйлчилгээний зардал	2,085.1	1,987.5	1,207.1	1,319.4	0.0	0.0	19.2	16.8
Зээлийн үйлчилгээний төлбөр	987.2	927.2	0.0	0.6	60.7	59.8	0.0	0.0
Татаас	78.1	77.3	77.0	79.3	0.0	0.0	92.5	67.7
Урсгал шилжүүлэг	2,062.0	2,039.2	415.4	450.8	223.2	218.8	1,650.0	1,696.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,909.0	1,846.0	438.0	453.3	0.0	0.0	3.0	5.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	628.2	490.1	0.1	11.5	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-4,183.1	-3,513.2	-36.6	-154.9	-114.2	-89.4	-12.4	89.7

Эх сурвалж: Сангийн яам

2016 оны төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 382.4 тэрбум, хүний хөгжил сангийн зарлага 5.3 тэрбум төгрөгөөр дутуу, харин орон нутгийн төсвийн зарлага 177.2 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 21.4 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагдсан байна.

2015 онтой харьцуулахад улсын төсвийн нийт зардал 2,370.4 тэрбум, орон нутгийн төсөв 235.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 244.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн, харин хүний хөгжил сангийн зардал 29.9 тэрбум төгрөгөөр буурчээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оноос 33.4 хувиар буюу 2,381.9 тэрбум төгрөгөөр өсөхөд бараа үйлчилгээний зардал 12.9 хувиар буюу 361.8 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 35.1 хувиар буюу 256.5 тэрбум, урсгал шилжүүлэг 41.7 хувиар буюу 688.5 тэрбум, хөрөнгийн зардал 65.0 хувиар буюу 907.9 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.1 дахин буюу 478.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Харин татаас 58.1 хувиар буюу 311.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/Зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/сая төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2016 оны урьдчилсан гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	ХУВЬ	ЗӨРҮҮ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,138.0	9,693.4	9,519.9	98.2	173.5
НИЙТ ЗАРЛАГА	7,115.1	9,065.1	9,018.3	99.5	46.9
УРСГАЛ ЗАРДАЛ	5,718.4	6,715.1	6,713.7	100.0	1.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,801.7	3,153.3	3,163.4	100.3	-10.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,709.8	1,722.0	1,742.1	101.2	-20.1
Үндсэн цалин	1,511.6	1,458.0	1,527.7	104.8	-69.7
Нэмэгдэл	72.1	126.2	85.7	67.9	40.6
Унаа хоолны хөнгөлөлт	32.0	37.6	33.7	89.5	3.9
Урамшуулал	55.0	60.8	56.3	92.6	4.5
Гэрээт ажлын хөлс	39.2	39.4	38.8	98.5	0.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157.7	158.1	160.2	101.3	-2.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186.9	232.4	224.7	96.7	7.7
Гэрэл, цахилгаан	34.6	43.5	42.8	98.4	0.7
Түлш, халаалт	118.6	148.2	143.1	96.6	5.1
Цэвэр, бохир ус	18.4	24.5	21.0	85.7	3.5
Байрны түрээс	15.4	16.2	17.9	109.9	-1.6
Хангамж, бараа материалын зардал	114.0	68.8	117.8	171.1	-49.0
Бичиг хэрэг	8.9	7.2	9.5	130.6	-2.2
Тээвэр, шатахуун	40.2	38.2	41.4	108.3	-3.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11.0	9.6	11.5	119.4	-1.9
Ном, хэвлэл	5.9	3.1	3.7	116.1	-0.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41.1	4.3	41.8	964.4	-37.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6.9	6.3	9.9	158.9	-3.7
Нормативт зардал	209.3	265.3	254.9	96.1	10.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86.0	120.0	117.7	98.1	2.3
Хоол, хүнс	97.9	113.4	103.9	91.6	9.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	25.4	31.9	33.2	104.1	-1.3
Эд хогшил, урсгал засварын зардал	36.1	31.1	43.5	139.9	-12.4
Багаж, техник, хэрэгсэл	8.5	9.1	11.6	127.3	-2.5
Тавилга	3.6	1.9	4.2	226.3	-2.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.4	0.7	0.6	92.5	0.1
Урсгал засвар	23.5	19.5	27.1	139.2	-7.6
Томилолт, зочны зардал	31.9	18.3	19.5	107.0	-1.3


Гадаад албан томилолт	11.5	4.8	5.3	110.6	-0.5
Дотоод албан томилолт	16.3	11.8	11.8	100.2	0.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	4.1	1.7	2.5	143.3	-0.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	320.1	391.6	332.7	85.0	58.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	293.3	349.3	280.7	80.4	68.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.9	1.5	1.0	68.0	0.5
Даатгалын үйлчилгээ	7.8	9.0	8.3	92.1	0.7
Тээврийн хэрэгслийн татвар	0.5	0.6	0.6	87.4	0.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.1	70.6	0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5.6	5.1	4.6	90.3	0.5
Газрын төлбөр	0.6	1.0	1.0	94.6	0.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4.2	14.5	26.6	183.1	-12.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7.0	10.3	9.9	95.6	0.4
Бараа үйлчилгээний бусад зардал	193.6	423.9	428.3	101.0	-4.4
Бараа үйлчилгээний бусад зардал	170.3	402.3	403.9	100.4	-1.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23.3	21.6	24.3	112.5	-2.7
ХҮҮ	731.1	1,047.9	987.6	94.2	60.3
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	192.2	344.3	342.2	99.4	2.1
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	538.9	703.6	645.4	91.7	58.2
ТАТААС	535.8	247.7	224.4	90.6	23.4
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	22.9	29.6	20.6	69.4	9.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	512.9	218.1	203.8	93.5	14.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,649.8	2,266.1	2,338.3	103.2	-72.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-420.5	16.3	30.0	184.0	-13.7
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-423.7	10.3	25.7	249.5	-15.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3.2	6.0	4.2	71.0	1.7
Бусад урсгал шилжүүлэг	2,070.3	2,249.9	2,308.3	102.6	-58.5
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,350.3	1,474.2	1,525.6	103.5	-51.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	486.2	518.1	489.8	94.5	28.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13.4	11.9	11.9	100.4	-0.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146.4	127.7	160.8	125.9	-33.1
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.1	0.1	72.2	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31.9	92.0	88.6	96.3	3.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэ	29.4	25.7	25.1	97.6	0.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал	12.8	0.3	6.5	21.7	-6.2

урамшуулал				дахин	
Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж	0.0	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,396.7	2,350.0	2,304.6	98.1	45.5
<i>Дотоод эх үүсвэрээр</i>	<i>1,150.6</i>	<i>1,839.9</i>	<i>1,699.0</i>	<i>92.3</i>	<i>141.0</i>
Барилга байгууламж	442.3	956.2	1,133.0	118.5	-176.8
Их засвар	110.8	43.3	146.9	339.3	-103.6
Тоног төхөөрөмж	20.4	51.4	63.0	122.5	-11.6
Бусад хөрөнгө	136.2	469.3	117.7	25.1	351.6
Стратегийн нөөц хөрөнгө	7.3	8.1	4.7	58.4	3.4
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	433.7	311.6	233.6	75.0	78.0
<i>Гадаад эх үүсвэрээр</i>	<i>246.1</i>	<i>510.1</i>	<i>605.6</i>	<i>118.7</i>	<i>-95.5</i>
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22.9	628.3	501.6	79.8	126.6
Эргэж төлөгдөх зээл	-17.6	601.6	471.0	78.3	130.6
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	40.5	26.7	30.6	114.9	-4.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин төлөвлөсөн хэмжээнээс 1.2 пунктээр нэмэгдэж 70.5 хувь болжээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 70.5 хувь буюу 6,713 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байгаагийн 47.1 хувь нь бараа, ажил үйлчилгээний зардал, 14.7 хувь нь зээлийн үйлчилгээний төлбөр, 3.3 хувь нь татаас, 34.8 хувь нь урсгал шилжүүлэгт ногдож байна.



Өнгөрсөн оноос нэгдсэн төсвийн урсгал зардал 995.3 тэрбум төгрөгөөр өсөхөд бараа, ажил үйлчилгээний зардал 361.8 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 256.5 тэрбум төгрөг болон урсгал шилжүүлэг 688.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар 33 төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 244.3 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Улсын төсвийн нийт зарлагын 25.5 хувийг Сангийн сайдын, 17.7 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын, 14.3 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайдын, 10.5 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын, 9.6 хувийг Эрүүл мэндийн сайдын, 5.9 хувийг Хууль зүйн сайдын, үлдэх 16.5 хувийг төсвийн бусад ерөнхийлөн захирагчдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2016 оны урьдчилсан гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	3,769.3	3,618.5	150.7	96.0
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	20,850.2	19,504.3	1,345.9	93.5
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	186,023.9	179,382.2	6,641.7	96.4
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	19,483.8	14,989.4	4,494.3	76.9
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	74,338.4	69,046.7	5,291.7	92.9
САНГИЙН САЙД	1,926,211.5	1,754,242.2	171,969.3	91.1
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	216,259.4	206,742.3	9,517.1	95.6
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	672,289.7	662,987.1	9,302.6	98.6
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	790.3	790.3	0.0	100.0
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3,412.5	3,334.8	77.7	97.7
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	48,267.9	47,859.8	408.2	99.2
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	17,660.2	17,652.8	7.4	100.0
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	2,042.4	1,946.7	95.7	95.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	9,396.9	9,324.4	72.5	99.2
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	2,891.9	2,437.8	454.1	84.3
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,909.7	2,675.9	233.8	92.0
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	498.2	498.0	0.2	100.0
ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА	0.0	0.0	0.0	0.0
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	475.3	463.4	11.9	97.5
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	119,990.9	117,873.1	2,117.9	98.2
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	31,017.6	28,594.6	2,423.1	92.2
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	731.6	731.6	0.0	100.0
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	8,785.6	8,852.9	-67.2	100.8
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	54,114.0	49,159.3	4,954.7	90.8
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	413,828.4	404,026.6	9,801.7	97.6
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	65,257.6	65,933.0	-675.4	101.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,247,832.3	1,215,572.9	32,259.4	97.4
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	936,329.9	981,155.3	-44,825.4	104.8
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	17,862.0	16,420.4	1,441.6	91.9
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	141,601.9	136,816.3	4,785.7	96.6
ХӨДӨЛМӨРИЙН САЙД	1,143.7	728.5	415.2	63.7
ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	29,321.1	29,232.1	89.0	99.7
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	109,899.7	101,862.6	8,037.1	92.7
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД	1,886.7	1,775.0	111.8	94.1
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	734,295.8	720,912.0	13,383.8	98.2
НИЙТ ЗАРДАЛ	7,121,470.4	6,877,142.8	244,327.5	96.6

Эх сурвалж: Сангийн яам

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Чингис бонд болон Хөгжлийн банкны эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэхээр төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээнд 237.0 тэрбум төгрөг зарцуулж, 76.1 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2016 оны урьдчилсан гүйцэтгэл
Хүснэгт 7. /сая төгрөгөөр/

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих	2016 оны урьдчилсан гүйцэтгэл /өссөн дүнгээр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Авто зам	271,584.0	65,619.4	65,619.4	51,608.3	14,011.1	78.6
Гудамж төсөл	63,402.2	8,309.3	8,309.3	7,288.2	1,021.1	87.7
Инженерийн дэд бүтэц	129,556.0	28,233.7	28,233.7	24,338.2	3,895.4	86.2
Гэр хорооллын дэд бүтэц	61,002.0	5,200.4	5,200.4	1,178.6	4,021.8	22.7
Эгийн голын усан цахилгаан станц	59,535.0	1,633.3	1,633.3	1,633.3	0.0	100.0
Амгалан дулааны станц	151,473.3	63,801.6	63,801.6	28,344.9	35,456.7	44.4
2016 оны төсвийн тухай хуулийн дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх бусад төслүүд	600,111.2	138,780.0	138,780.0	122,614.1	16,165.9	88.4
НИЙТ ДҮН	1,336,663.7	311,577.8	311,577.8	237,005.7	74,572.1	76.1

Эх сурвалж: Хөгжлийн банк

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 246.7 тэрбум төгрөг зарцуулж, 81.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 303.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 246.7 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 56.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл, /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Хүснэгт 8. /сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТӨСӨВ	2016 оны урьдчилсан гүйцэтгэл			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	667.1	667.1	667.1	591.0	76.1	88.6
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	8,100.0	8,100.0	8,100.0	5,322.4	2,777.6	65.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	10,382.0	3,082.4	3,082.4	3,014.5	67.9	97.8

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	12,043.5	3,195.2	3,195.2	2,843.4	351.8	89.0
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	1,682.2	550.3	550.3	531.9	18.4	96.6
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4,460.0	601.2	601.2	601.2	0.0	100.0
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	7,304.2	5,781.6	5,781.6	5,672.8	108.8	98.1
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	66,197.5	24,805.6	24,805.6	23,862.3	943.3	96.2
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	103,871.2	18,807.2	18,807.2	16,603.2	2,204.0	88.3
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	27,777.1	2,639.5	2,639.5	1,953.0	686.5	74.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	493,649.4	115,962.6	115,962.6	101,213.5	14,749.2	87.3
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	325,512.3	65,564.4	65,564.4	37,596.0	27,968.4	57.3
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	17,822.3	1,193.1	1,193.1	1,010.9	182.2	84.7
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	177,205.2	47,426.0	47,426.0	40,856.3	6,569.7	86.1
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	16,766.5	3,935.8	3,935.8	3,677.0	258.8	93.4
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	475.0	475.0	475.0	473.4	1.6	99.7
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	1,693.7	845.2	845.2	845.1	0.1	100.0
НИЙТ ДҮН	1,275,609.2	303,632.2	303,632.2	246,667.8	56,964.4	81.2

Эх сурвалж: Сангийн яам

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид нийт 659.2 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад шилжүүлсэн байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Хүснэгт 9.

/сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТӨСӨВ	2016 оны эхний 11 сарын гүйцэтгэл			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	25,781.3	1,744.9	1,744.9	1,744.8	0.2	100.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	30,291.5	6,666.8	6,666.8	6,350.3	316.4	95.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	948.6	31.4	31.4	30.4	1.0	96.7
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	1,093.5	429.4	429.4	429.4	0.0	100.0
САНГИЙН САЙД	31,802.8	10,914.7	10,914.7	8,640.3	2,274.4	79.2
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	106,610.3	9,744.4	9,744.4	9,686.8	57.6	99.4
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	47,429.0	11,962.6	11,962.6	11,692.2	270.3	97.7
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	97,713.5	32,154.2	32,154.2	31,928.7	225.5	99.3
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	54,239.4	3,307.7	3,307.7	2,943.1	364.6	89.0

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	450,054.7	54,402.2	54,402.2	51,071.3	3,330.9	93.9
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	908,285.2	436,291.5	436,291.5	434,771.6	1,520.0	99.7
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	49,401.0	7,737.6	7,737.6	6,610.2	1,127.4	85.4
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	173,379.9	16,168.4	16,168.4	14,938.0	1,230.4	92.4
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	361,893.4	80,730.7	80,730.7	77,759.4	2,971.4	96.3
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	3,867.1	643.1	643.1	643.0	0.1	100.0
НИЙТ ДҮН	2,342,791.3	672,929.5	672,929.5	659,239.4	13,690.2	98.0

Эх сурвалж: Сангийн яам

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр гүйцэтгэсэн “Мандал сум (Зүүн хараа) чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам” төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд нийт 13.1 тэрбум төгрөг, “Алтанбулаг сумыг цэвэр усны эх үүсвэртэй холбох төсөл”-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд нийт 400.0 сая төгрөг, “Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэй ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км хатуу хучилттай авто зам” төслийн хөрөнгө оруулалтад нийт 57.2 тэрбум төгрөг тус тус төлөвлөснөөс 100.0 хувь гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

5. Хүний хөгжил сан

Хүний хөгжил сангаас 218.8 тэрбум төгрөгийг хүүхдэд олгов.

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Хүний хөгжлийн санд нийт 169.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 19.4 тэрбум төгрөг буюу 11.4 хувиар давж байна. Энэ нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын өсөлттэй холбоотой байна.

Хүний хөгжил сангийн орлого

Хүснэгт 10.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Жилийн төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	169,703.4	169,703.4	189,095.1	19,391.7	111.4
1.Татварын орлого	166,004.7	166,004.7	187,664.2	21,659.9	113.0
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	166,004.7	166,004.7	187,664.2	21,659.9	113.0
2.Татварын бус орлого	3,698.8	3,698.8	1,430.9	-2,267.8	-
Хувьцааны ногдол ашиг	3,000.0	3,000.0	-	-	-
3.Бусад орлого	698.8	698.8	1,430.9	732.2	-
Ханшны өөрчлөлт	698.8	698.8	1,430.9	732.2	-

Эх сурвалж: Сангийн яам

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Хүний хөгжил сангийн зарлага 278,5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн зардал 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүний хөгжил сангаас Засгийн газрын бондын хүү буюу зээлийн үйлчилгээний төлбөрт 59.8 тэрбум төгрөг, 18 хүртэлх насны хүүхдэд 218.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хүснэгт 11. Хүний хөгжил сангийн зарлага


Хүснэгт 11. Үзүүлэлт	Жилийн төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Зөрүү	Хувь
		Өссөн дүнгээр			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	283,867.0	283,867.0	278,525.2	5,341.8	98.1
Төр хариуцах иргэдийн хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хүүхдэд олгох бэлэн мөнгө	223,200.0	223,200.0	218,757.1	4,442.9	98.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	60,667.0	60,667.0	59,768.1	898.9	98.5
Хөрөнгийн зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

6. Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн зарлага төлөвлөсөн хэмжээнээс 21.4 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Нийгмийн даатгалын санд 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 1,875.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 123.4 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, орлогын гүйцэтгэл 107.0 хувьтай байна. Нийт орлого өмнөх оноос 395.4 тэрбум төгрөгөөр буюу 26.7 хувиар өссөн байна. Тус санд улсын төсвөөс 494.9 тэрбум төгрөгийн татаасыг олгожээ.




Нийгмийн даатгалын таван төрлийн санд 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлого 1381.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 172.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байдлаар авч үзвэл, тэтгэврийн даатгалын санд 789.3 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 90.6 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 133.1 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 41.2 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 326.9 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн нийт зардалд 1,764.8 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бусад зардалд нийт 1,786.2 тэрбум төгрөгийг зарцуулснаар 101.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөсөн хэмжээнээс илүү зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн нийт зардал 225.8 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 170.1 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 1,786.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 244.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 17.9 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 4.0 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 68.2 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сан 15.7 тэрбум, тэтгэврийн даатгалын сангын зарлага 120.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ



График 10. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /хувиар/



зарцуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 1,331.0 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 94.3 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 48.9 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид болон бусад зардалд 39.0 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгийн тусламж, үйлчилгээ, рашаан сувилал, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад зардалд 273.0 тэрбум төгрөгийг тус тус

7. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн зарлага төлөвлөснөөс 177.2 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагдсан байна.


Орон нутгийн төсвийн орлого 2,160.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 2.8 хувь буюу 58.9 тэрбум төгрөгөөр давж биелэсэн, харин нийт зарлага нь 2,314.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 8.3 хувиар буюу 177.2 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 6.2 хувиар буюу 126.2 тэрбум төгрөгөөр, мөн нийт зарлага 11.3 хувиар буюу 235.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 41.0 хувь нь орон нутгийн төсвийн орлого, 7.0 хувь нь улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 46.0 хувь нь тусгай зориулалтын шилжүүлэг, 6.0 хувь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 151.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ. Мөн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 995.0 тэрбум төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр аймгуудад олгосон байна.

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр аймгуудын орон нутгийн хөгжлийн санд 120.3 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.



Аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 12.

	ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	37,444.8	37,243.7	99.5	3,179.9	3,179.9	100.0
Баян-Өлгий	46,329.8	46,202.3	99.7	3,260.1	3,260.1	100.0
Баянхонгор	36,416.4	35,444.5	97.3	4,737.8	4,737.8	100.0
Булган	28,297.1	26,661.8	94.2	3,550.5	3,550.5	100.0
Говьсүмбэр	7,758.4	7,700.4	99.3	2,227.4	2,227.4	100.0
Говь-Алтай	32,237.0	30,720.2	95.3	5,693.7	5,693.7	100.0
Дархан-Уул	31,927.4	31,635.3	99.1	3,295.3	3,295.3	100.0
Дорноговь	27,286.9	27,215.0	99.7	5,579.9	5,579.9	100.0
Дорнод	29,574.1	29,179.1	98.7	4,140.6	4,140.6	100.0

Дундговь	22,208.7	22,086.6	99.5	4,114.7	4,114.7	100.0
Завхан	35,432.4	35,427.5	100.0	4,185.8	4,185.8	100.0
Орхон	31,729.2	31,161.0	98.2	3,562.0	3,562.0	100.0
Өвөрхангай	42,044.9	42,061.9	100.0	3,444.4	3,444.4	100.0
Өмнөговь	27,439.0	27,034.6	98.5	21,515.0	21,515.0	100.0
Сүхбаатар	28,117.7	28,072.2	99.8	7,681.2	7,681.2	100.0
Сэлэнгэ	43,171.6	42,747.4	99.0	4,887.3	4,887.3	100.0
Төв	40,606.1	40,106.2	98.8	6,300.9	6,300.9	100.0
Увс	38,081.0	37,645.1	98.9	3,040.6	3,040.6	100.0
Улаанбаатар	294,799.7	291,654.4	98.9	14,393.7	14,393.7	100.0
Ховд	37,711.9	37,711.7	100.0	3,664.1	3,664.1	100.0
Хөвсгөл	54,248.6	53,980.1	99.5	3,395.6	3,395.6	100.0
Хэнтий	33,433.3	33,297.9	99.6	4,417.2	4,417.2	100.0
ДҮН	1,006,295.9	994,989.0	98.9	120,267.7	120,267.7	100.0

Эх сурвалж: Сангийн яам

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА